

КРИМИНОЛОГИЙН СОНГОДОГ ОНОЛЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

COMPARATIVE STUDY OF CLASSICAL THEORIES OF CRIMINOLOGY

Б.Мөнхзул

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн ахлах багш, докторант, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Энэхүү илтгэл нь криминологийн сонгодог онолын харьцуулсан судалгаа, түүний үүсэл, хөгжлийн талаар судалсан болно. Сонгодог криминологийн онол нь 18-р зуунд Чезаре Беккариа, Жереми Бентам зэрэг эрдэмтдийн үзэл санаанаас үүдэлтэй бөгөөд гэмт хэргийн шалтгааныг хувь хүний сонголт, оновчтой шийдвэр гаргалтад суурилан тайлбарладаг, хүний эрх, шударга ёсыг хамгаалах зарчмаар ял шийтгэлийн үр нөлөөг онцолж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хууль зүйн зохицуулалт, шийтгэлийн үр дагаврыг чухалчилдаг.

Илтгэлд криминологийн сонгодог онолын үндсэн зарчмуудын талаар авч үзэж, криминологийн судалгааны хандлагыг Азийн болон Европын криминологичдын судалгаанд тулгуурлан харьцуулан дүгнэж, орчин үеийн эрүүгийн бодлогод хэрхэн нөлөөлж буйг судлахыг зорьсон.

Abstract: This paper examines the comparative study of classical criminological theories, their origins and development. Classical criminological theories originated in the 18th century from the ideas of scholars such as Cesare Beccaria and Jeremy Bentham, and explain the causes of crime based on individual choice and rational decision-making, emphasize the effectiveness of punishment based on the principles of protecting human rights and justice, and emphasize the importance of legal regulation and the consequences of punishment in preventing crime.

The paper aims to review the basic principles of classical criminological theories, compare and summarize the approaches to criminological research based on the research of Asian and European criminologists, and examine how they affect modern criminal policy.

Түлхүүр үгс: Сонгодог онол, гэмт хэрэг, ял шийтгэл, шийтгэлийн үр нөлөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шударга ёс, нийгмийн гэрээ

Keywords: Classical theory, crime, punishment, effectiveness of punishment, crime prevention, justice, social contract

Үндсэн хэсэг

Криминологийн сонгодог онол нь эрүүгийн ял, шийтгэлийн үндсийг ойлгох, түүнийг тайлбарлах онолыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ба XVIII зууны соён гэгээрлийн үед Италийн судлаач Чезаре Беккариа, Английн Жереми Бентам нарын бүтээлээр дамжин, философийн сургаал дээр үндэслэн үүссэн.

Сэргэн мандалтын үеийн парадигм (нэг систем, үзэл санаа, эсвэл онолын хүрээнд хийгдсэн судалгаа, ойлголт, арга барил), рациональ (учир зүй, логик) ба үзэл санаануудын үндэс суурин дээр хөгжиж, гэмт явдлыг хувь хүний сонголт гэж үзсэн сонгодог үзэл баримтлал нь дундад зууны гэмт хэрэгтнийг хэрцгий, бүдүүлэг хүмүүс гэж үздэг байсан байдлыг шүүмжилж, хүний эрх, нэр төрийг хамгаалсан үзэл санааг анхлан дэвшүүлсэн.

Энэ утгаараа сонгодог онол нь гэмт явдал, ял шийтгэлийг ойлгох өнцгийг эрс өөрчилж, одоог хүртэл нөлөөгөө алдаагүй байгаа ба дэвшүүлсэн томьёолол нь орчин үеийн ардчилсан Эрүүгийн эрх зүйн тогтолцооны үндэс суурь болж байна.

Сонгодог үзэл баримтлалын дагуу гэмт хэрэг, зөрчлийг хүн ойлгож, ухамсарлаж, хүсэж үйлддэг гэж үздэг ба Жереми Бентамын “ашгийн философи”-д хүний аливаа үйлдэлд хоёр хүчин зүйл нөлөөлдөг нь ашиг, таашаал байдаг гэж үздэг. Энэ нь хүний үйлдэл хийх

сонголтод нөлөөлснөөр гэм буруутай үйлдэл үйлдэгддэг гэж үзсэн. Хүмүүс аливаа шийдвэр, сонголтоор ашиг хонжоо, таашаал авах зорилготой байдаг. Гэм буруутай аливаа үйлдэл ихэвчлэн тухайн хүний хувьд үр ашиг ихтэй, гарз хохирол багатай байхаар бол тухайн үйлдлийг хийх магадлал ихэснэ. Ийм учраас сонгодог үзэл баримтлалд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга нь ял шийтгэлийг чангатгаснаар рациональ сонголт болохоос сэргийлэх явдал юм. Ял шийтгэл нь тухайн этгээдийг гэмт үйлдэл хийхээс сэргийлэх хэрэгсэл болохоос гарцаагүй, шуурхай, тухайн үйлдэлд нь тохирсон байх нийтлэг шаардлагатай байдаг. Гэхдээ хүний сонголт бүхэн оновчтой байдаггүй, бүх гэмт явдлууд сонголтоос үүсдэггүй тул хязгаарлагдмал томьёолол юм.

Энэ онол нь гэмт хэрэг, ял шийтгэлийн талаарх түүний хэтийн төлөвийг тодорхойлдог хэд хэдэн үндсэн зарчим дээр суурилдаг:

- Оновчтой ухаалаг байдал: Энэ нь гэмт хэрэг нь хувь хүний чөлөөт, оновчтой сонголтын үр дүн байдаг ба хүмүүс гэмт хэрэг үйлдэх шийдвэр гаргахаасаа өмнө үйлдлийнхээ боломжит үр ашиг, зардлын тооцоонд үндэслэн шийдвэр гаргадаг ухаалаг амьтад гэж үздэг. Өөрөөр хэлбэл ашиг нь учирч болзошгүй эрсдэлээс давсан тохиолдолд хүмүүс гэмт хэрэг үйлддэг.
- Гедонизм: Сонгодог криминологийн дагуу хүмүүс таашаал ханамжийг эрэлхийлж, өвдөлтөөс зайлсхийж байдаг. Иймээс гэмт хэргийн зан үйл нь таашаал авах, зарим төрлийн өвдөлтөөс ангижрах хэрэгсэл болдог.
- Шийтгэл: Сонгодог криминологи нь тодорхой шийтгэл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэдгийг онцолдог ба шударга ёсыг дур зоргоороо ашиглах, хэт хатуу, зохисгүй шийтгэлийг үгүйсгэх хэрэгтэй хэмээн үздэг. Гэмт хэрэгтнүүдийн урмыг хугалахын тулд шийтгэл нь гэмт хэрэг үйлдсэний үр ашгаас давахуйц хатуу байх ёстой, гэхдээ хэт хатуу биш.
- Чөлөөт хүсэл: Сонгодог криминологи нь хувь хүн чөлөөт сонголттой, сонголт хийх чадвартай ба хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээдэг. Энэ нь хувь хүмүүс өөрсдийнх нь хяналтаас гадуур гаднын хүчин зүйлийн нөлөөнд автдаг гэсэн детерминизмын ойлголтыг үгүйсгэдэг.

Сүүлийн жилүүдэд Криминологийн салбарт, тэр дундаа онолын талаар судлаачид Монгол хэл дээр бүтээд туурвих нь харьцангуй ихсэж байгаа ба тухайлбал, Д.Зүмбэрэлхам, Б.Мөнх-Эрдэнэ, Осман Долу (орчуулсан Э.Дашгаадан) нарын эрдэмтэд сонгодог онолын талаар бүтээлдээ дараах байдлаар тусгажээ (Д.Зүмбэрэлхам, 2022), (Б.Мөнх-Эрдэнэ, 2021), (Э.Дашгаадан, 2022)

Криминологийн сонгодог онол бол гэмт явдлыг дундад зууны үед шашны номлолын үүднээс далдын буюу ертөнцөөс гадуурх ер бусын хүчний нөлөөгөөр тайлбарлаж, гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хүнлэг бус харгис арга хэлбэрээр залхаан цээрлүүлдэг ёсыг халахад чиглэгдсэн хүнлэг, энэрэнгүй ёсны үүднээс хандах зарчимд суурилсан үзэл санаа цаашлаад криминологийн "сонгодог" болон "шинэ сонгодог" хэмээн нэрлэгдэх онолын үзэл баримтлалуудаар тайлбарлагддаг.

Дундад зууны үед Европын Барууны орнуудад гэмт хэрэг, зөрчлийн үйлдэгдэх шалтгаан “ер бусын хүчин”-ий нөлөө буюу сүнс, чөтгөр, шулам зэргээс үүдэлтэй нүгэл гэж үзэж байв.

Тухайн үеийн феодалын нийгэмд хаад ноёдын эрх мэдэл болон нийтийн эрх ашгийг үл зөвшөөрөх, хүчтэй нь хүчгүйгээ дарангуйлах зэрэг харгис хэрцгий байдал газар авч хааны ордныхон, язгууртан, баячууд, хөрөнгөтнүүд, феодал ноёд бүхий л эрх мэдлийг эзэмшихээс гадна Шүүн таслах тогтолцоог хүссэнээрээ чиглүүлдэг байв. Ихэнх гэмт үйлдлийн ял шийтгэлийг хууль журмаар зохицуулаагүй байсан бөгөөд шүүн таслах эрх бүхий албан тушаалтан хэрхэн үзсэнээр шийдвэрлэгддэг байв. Тухайн үед шүүгч нарын

шийдвэр хууль, шударга ёсонд үндэслээгүй хувийн ашиг сонирхолд тулгуурладаг, ял шийтгэл маш харгис хэрцгий байж. Гэм бурууг хүлээлгэхийн тулд төрөл бүрийн эрүү шүүлт тулгах, хүний ёсноос гажууд үйлдлүүд хийх нь энгийн үзэгдэл байжээ. Ял шийтгэлийн хувьд гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн гэх таамаг байгаа зэргээс шалтгаалан харилцан адилгүй байв. Авлига авсан хүний толгойг авах тохиолдол ч байсан. Гэмт хэргийн тодорхойлолт гэж байсангүй. Ямар үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцох түүнд ямар ял шийтгэл оногдуулах талаар хууль, журам байхгүй байсан нь маш эмх замбараагүй зохицуулалттай байсныг илтгэнэ.

Цаашлаад 1700-1800 оны сонгодог үзэл баримтлалыг авч үзвэл тухайн үеийн шударга бус тогтолцоо, үзэл суртлыг эсэргүүцэн Англид Томас Хоббс, Жон Локк, Жереми Бентам, Францад Чарльз Монтескье, Волтейр, Жан Жак Руссо, Клауд Хелветус, Давид Хюм, Адам Смит, Германд Эмануель Кант болон Италид Чезаре Беккариа зэрэг эрдэмтдийн шинэ үзэл санаа нь Европоор тогтохгүй бүх дэлхийд өөрчлөлтийг авчирсан байна. Хувьсгал, шинэчлэлийн хөдөлгөөнүүд энэ үед хүчтэй нөлөө үзүүлж, “Сэргэн мандалтын үе” хэмээн нэрлэгджээ. Энэ үед эрүүгийн эрх зүйн системд шинэ асуудлууд тулгарч, томоохон өөрчлөлтүүд бий болсон. Дээр дурдагдсан эрдэмтэд ялангуяа Беккариа, Бентам нар хууль гэдэг бол бичигдмэл, хүн бүрд ойлгомжтой байх, гэмт үйлдэлд тооцсон үйлдлүүд тодорхой байх, ял шийтгэл нь хурдан шуурхай, эрх тэгш үйлчлэх, шийтгэл нь үйлдэлдээ тохирсон байх шаардлагатай бөгөөд эрүүдэн шүүх, нууцаар байцаах, дур зоргоор шийтгэх, цаазаар авах зэргийг халах шаардлагатай хэмээн үзэж байжээ.

Дундад зууны хаад ноёдын эрх мэдэл хэмжээгүй эрхтэй гэсэн ойлголт түгээмэл байсан ба энэ эрх дарх нь бурхны шийдвэр мэт дагаж мөрдөх нь гарцаагүй байлаа. 1651 онд хэвлэгдсэн Leviathan нэртэй нийтлэлдээ Хоббс хүн бүр нийгмийн гишүүн тул тэгш эрхтэй гэсэн үзлээрээ хаад ноёдын хэмжээгүй эрхийг шүүмжилсэн. Хэдий тийм ч гэлээ Хоббс нийгмийн гишүүд эрх чөлөөтэй, аюулгүй амьдрахын тулд төрийн эрх мэдэл шаардлагатай бөгөөд тухайн эрх мэдэл нь хүмүүсийн дундын хүсэл эрмэлзлийг үндэслэн бий болох боломжтой гэдэг санааг дэвшүүлсээр байжээ.

Энэ ойлголтод тулгуурлан Ж.Руссо, Ж.Локк болон Хоббс нар нийгмийн гишүүн бүр эрх чөлөөтэй амьдрахын тулд “Нийгмийн гэрээ” /Social contract/ шаардлагатай, нийгмийн аюулгүй байдлыг хангахын тулд хүн бүрийн эрх чөлөөг тодорхой хэмжээгээр төрийн зүгээс хязгаарлах хэрэгтэй гэж үзсэн. Энэ ч утгаараа сонгодог үзэл баримтлалд гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж үндсэндээ нийгмийн гэрээг зөрчсөн үйлдэл буюу шийтгэл оногдуулахуйц эрх зүйн зөрчлүүд байжээ. Хоббсын энэ санаа Беккариад маш хүчтэй нөлөөлж, өөрийн санааг улам боловсронгуй болгох түлхэц болжээ.

Сонгодог үзэл баримтлалаар гагцхүү төрийн дээд эрх мэдлийг ард иргэдэд өгөх хэрэгтэй ба гэмт хэрэг зөрчил үйлдсэн нь батлагдаагүй бол хэнийг ч яллаж болохгүй, хүний эрх, эрх чөлөөг, аюулгүй байдал, хувийн амьдралд ямар ч тохиолдолд дур зоргоороо халдахгүй байх зэрэг санааг дэвшүүлсэн.

Дундад зууны сонгодог үзэл баримтлалаар гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл нь ер бусын хүчин зүйл биш хүний өөрийнх нь сонголт, шийдвэрээс үүдэн бий болдог гэх үзэл дэлгэрсэн юм. Тухайн үеийн эрдэмтэд дараах онцлогуудыг төрөлхөөс заяагдмал гэж үздэг.

- Өөрийн эрх ашгийг боддог, харамч
- Гедонист шинжтэй, таашаал авахын төлөө амьдардаг. Зовлонгоо багасгах, таашаалыг илүү хүртэхийг хүсдэг.
- Рациональ шинжтэй. Ашиг хонжоо, эрсдэлийг тооцоолдог. Тухайн үйл явцын дараа бий болох сөрөг үр дагавар, өөрт бий болох ашиг хонжоог харьцуулдаг.

Сонгодог үзэл баримтлалд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нь хүмүүсийн хувиа бодсон зан, таашаал авах хүслээс үүддэг гэж үзэж байжээ. Мөн гэмт үйлдлийн үр дүнд олж

авах ашиг хонжоо нь гарах эрсдэл, гарз хохирлоос илүү байгаа тохиолдолд гэмт үйлдлийг сонгож үйлддэг.

1764 онд хэвлэгдсэн “Гэмт явдал ба ял шийтгэлийн тухай” /An essey on crime and punishment/ нийтлэлдээ Беккариа эрүүгийн эрх зүйн тогтолцооны хувьд шинэчлэл гэмээр санааг дэвшүүлсэн байдаг. Энэ нийтлэлд хуулийн агуулга, хэрхэн хуульчлах, хэрхэн тайлбарлах хэрэгтэйг, ял шийтгэлийн ач холбогдол зэргийг тусгажээ.

Беккариагийн үзсэнээр хуулийг хэрхэн ойлгох болон хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлах эрхийг ард иргэдийг төлөөлөх төрийн эрх мэдэлд болон шүүгч нарт байж болно. Ийм учраас шүүгчид аливаа үйлдэл, эс үйлдлийг хуульд тусгасан гэмт үйлдэлд тохирч байгаа эсэхийг шинжлэх эрхтэй гэж үзжээ.

Хууль гэдэг хүмүүсийн дур зоргоор авирлах, шударга бус байдлаас сэргийлэхийн тулд хүн бүрд ойлгомжтой байдлаар бичигдсэн байх шаардлагатай. Хүмүүс ямар үйлдэл, эс үйлдэл гэмт хэрэг зөрчлийн шинжтэй байдаг болохыг, түүний ял шийтгэлийн талаар, дээд доод хэмжээг тодорхой ойлгож байх хэрэгтэй юм. Эс үгүй бол хуулийг ташаа ойлгох, өөр өөрсдийн үзэл санааг дэвшүүлэх зэргээр нийгэмд сөрөг үзэгдлийг бий болгосноор хууль ойлгомжгүй, чанаргүй байна гэдэг шүүмжлэл дагуулж болзошгүй юм.

Харин шийтгэл нь хохирогчийн эд хөрөнгө, сэтгэл санааны хохирлын хэмжээнээс бус нийгэмд үзүүлсэн сөрөг үр нөлөөнд тулгуурлан оногдуулах ёстой байв. Төр эрх мэдлийнхээ хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд гэмт хэргийг хориглох, саатуулахад чиглэсэн хүч хэрэглэх бүрэн эрхтэй. Гэм буруутай үйлдэл бүхэнд өөр өөр ял шийтгэл оногдуулах шаардлагатай. Хүн амын тоо өсөх, нийгмийн хүрээ тэлэхэд гэмт хэрэг, зөрчил нь бусад нийгмийн асуудалтай хамт хүрээгээ тэлэх нь ойлгомжтой юм. Гэмт хэрэг, зөрчилгүй нийгэм гэж байхгүй. Бүх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэг, зөрчилгүй болно гэдэг бол огт боломжгүй зүйл юм. Хувиа бодсон, гедонист хүн төрөлхтөн үргэлж өөрийн ашиг хонжоог эрэлхийлж байдаг тул гэм буруутай үйлдэл гаргах нь тодорхой юм. Иймээс шийтгэл нь хүнийг тэр л хэмжээ хязгаарт нь барьж байх ерөнхий зорилгыг агуулдаг.

Сонгодог үзэл баримтлалд ял шийтгэл нь

- Хүнийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс сэргийлэх
- Гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх
- Хохирогчийн гомдлыг барагдуулах, тохирсон шийтгэл эдлүүлэх зэрэг зорилготой байдаг. Үүнээс гадна гэмт этгээдийг хорьж, нийгмээс тусгаарласнаар нийгмийг хамгаалах зорилгыг бас агуулдаг. Эндээс харахад Беккариагийн шийтгэлтэй холбоотой шинж тэмдэг нь нийтэд нээлттэй, хурдан, хэрэгцээтэй, байж болох хамгийн хөнгөн байх, гэмт үйлдэлд тохирсон хэмжээтэй, хуульд тусгасан байх зэрэг юм.

Беккариа нь шийтгэлийн зорилго бол шийтгэхдээ биш гэмт явдлаас урьдчилан сэргийлж, нийгмийг хор уршгаас хамгаалах гэж үзсэн. Иймээс шийтгэл гэдэг хүнийг ухамсарлуулахын тулд хүнлэг шинжтэй байх нь чухал юм. Энэ ч утгаараа Беккариа бусад сэргэн мандалтын үеийн эрдэмтэн судлаачдын адил цаазаар авах ялыг халж, түүний оронд илүү хүмүүнлэг шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзжээ.

Ял шийтгэл үр дүнтэй байх үүднээс Беккариа гурван үндсэн шинжийг гаргасан. Үүнд:

1. Гарцаагүй байх /certainly/
2. Түргэн шуурхай байх /celerity/
3. Тохирсон хэмжээтэй /severity/

Гарцаагүй байх нь бусад зарчмуудаас хамгийн чухал хүчин зүйл юм. Гарцаагүй байх болон гэмт хэрэг, зөрчил нь урвуу хамааралтай юм. Ял шийтгэлийн гарцаагүй байх шинж нэмэгдсэнээр гэм буруутай үйлдэл нийгэмд гарах нь багасна. Энэ талаар олон судалгаа хийгдсэн байдаг ба энэ л зарчмыг бүгд нотолсоор ирсэн. Ял шийтгэлээ эрт орой хэзээ нэгэн цагт заавал эдэлдэг гэсэн үзэл дэлгэрсэн цагт хүмүүс шийтгэлээс зугтах аргагүйг ойлгон гэм буруутай үйлдэл гаргахын өмнө сайтар бодож тунгаана. Шийтгэлээс зугтах боломж бага байх эсвэл боломжгүй байх нь жинхэнэ урьдчилан сэргийлэх үр дүнтэй нөхцөл юм.

Шийтгэлийг гэм буруутай үйлдэл гарсан даруйд оногдуулж байх нь маш чухал юм. Ийм учраас баривчлах, саатуулах зэрэг хууль хүчний байгууллагаас авч буй арга хэмжээтэй зэрэгцэн цаг алдалгүй шалган шийдвэрлэх үйл ажиллагааг явуулж, шийдвэр гаргах, тохирсон шийтгэлийг оногдуулах нь гэмт хэрэгтэнд ял шийтгэл оногдуулах гол зорилгуудын нэг юм. Энэ утгаараа Беккариа “Гэмт үйлдэл үйлдэгдсэн тохиолдолд шийтгэл нь хэдий чинээ түргэн шуурхай хэрэгжиж байвал төдий чинээ эрх тэгш байж, зорилгодоо хүрэх болно” гэж үзсэн.

Шийтгэл нь чанга, хатуу байх нь салшгүй нэг шинж юм. Гэхдээ Беккариагийн үзсэнээр чанга гэдэг нь шийтгэл гэмт буруутай үйлдэл хоёр тохирсон харьцаатай байхыг илэрхийлж байв. Хэдийгээр гэмт явдлыг хяналтандаа авах, үйлдэгдэх түвшинг бууруулах болон байж болох урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан ч бүхэлд нь урьдчилан сэргийлж чадахгүй нь мэдээж. Ялангуяа гэмт этгээд болон эрсдэлтэй этгээдийг ухамсарлуулахын тулд үйлдэгдсэн гэмт үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах шаардлагатай байдаг.

Гэмт хэрэг, зөрчилд тохиромжгүй шийтгэл оногдуулах нь нийгэмд үр нөлөөтэй чанарыг алдагдуулна. Шийтгэл нь гэмт үйлдлээсээ хөнгөн байвал тухайн гэмт үйлдлийг үйлдэх магадлал шууд нэмэгдэх юм. Шийтгэл нь илүү чанга болсон тохиолдолд гэмт этгээдэд хүнлэг бусаар хандсан, шударга бус байдал үүснэ. Ийм учраас аль ч тохиолдолд нь үр нөлөө үүсэхгүй. Жөффери хатуу чанга шийтгэл нь гэмт этгээдэд шударга бус байдалд орсон гэх үзэл санааг төрүүлж, эсэргүүцэл үзүүлэх, үл ухамсарлах байдлыг бий болгоно гэсэн бол Шерман хүнийг тохиромжгүй буюу илүү чанга шийтгэх нь уур бухимдал төрүүлэх, дахин гэмт үйлдэл гаргах байдлыг ч бий болгож болзошгүй гэж үзсэн.

Английн эрдэмтэн Жереми Бентам (1748-1832) хүмүүсийг зовлонгоос ангижрах болон ашиг хонжоог эрэлхийлж амьдардаг гэж үзэж байв. Энэ үзэл санааг 1789 онд хэвлэгдсэн “Ёс суртахуун ба амьдрах зарчим /An introduction to the Principles of Moral and Legislation/” нэртэй нийтлэлдээ ашгийн зарчмын талаар Бентам хууль болон ял шийтгэлтэй холбон Беккариагийн үзэл санаатай нийцүүлэн шүүн таслах шударга бус тогтолцоог шүүмжилсэн.

Ашгийн зарчмаар /utility principle/ ял шийтгэл гэдэг бол өөрөө нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд нийгэмд учруулсан гэмт хорыг илүү хохирол учруулахаас сэргийлж хэрэглэх арга байх ёстой гэжээ. Бентам үүнийг гедонист тооцоо гэж тодорхойлсон ба тухайн үйлдлийн үр дүнд үүсэх ашиг хонжоо болон ял шийтгэл, эрсдэлийг үнэлж, ашиг хонжоо илүү доош татаж байвал гэмт хэрэг, зөрчил үйлдэх магадлалтай, харин ял шийтгэл илүү доош татаж байвал гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс татгалзах магадлалтай гэж дүгнэжээ.

Бентамын үзсэнээр ял шийтгэл зарим тохиолдолд үр дүнгүй байдаг байна. Тиймээс шийтгэх зохицуулалтгүй буюу гэм хор учраагүй, шийтгэл үр дүнгүй буюу гэм хорыг таслан зогсоож чадахгүй бол, шийтгэл нь үр ашиггүй буюу шийтгэлийн зардал нь гэм хороос их байх, шийтгэх шаардлагагүй буюу гэм хорыг арилгах ямар ч нөлөөгүй тохиолдлуудад шийтгэл оногдуулахгүй байх нь зүйтэй гэжээ.

Үүнээс үзвэл Бентам шийтгэл оногдуулах нь үр дүнтэй байх шаардлагатай гэж үзсэн ба ял шийтгэлийн үр нөлөө нийгэмд учрах гэм хорыг харьцуулж үзэхэд үр нөлөө бага байвал тухайн шийтгэл ямар ч хэрэгцээгүй гэсэн үг юм. Ялангуяа тухайн үед гэмт явдал, ял шийтгэл

гэх ойлголтуудыг Хоббсын Leviathan-д өгүүлсэн нийгмийн гэрээ гэх ойлголтоор тайлбарлан өнөөгийн эрүүгийн эрх зүйн тогтолцооны үндсэн ухагдахууныг бүрэлдүүлж байна.

Орчин үед Криминологийн сонгодог онолыг Азийн эрдэмтэд хэрхэн үзэж байгааг харьцуулан авч үзвэл.

	Эрдэмтдийн нэрс	Улс	Он	Эх сурвалж	Судалгааны ажлын нэр	Судалгааны тойм
1	Лю Жианхун	БНХАУ	2014	Олон улсын гэмт хэрэг, шударга ёс, нийгмийн ардчиллын сэтгүүл	Азийн парадигмын онол	"Азийн парадигмын онол"-ын хөгжил, түүний криминологи дахь үр нөлөөг авч үзсэн.
2	Ким Ён Сү	Солонгос	2019	Солонгосын Криминологийн сэтгүүл	Сонгодог криминологи ба түүний Өмнөд Солонгос дахь хэрэглээ	Сонгодог криминологийн онолууд Өмнөд Солонгосын хууль эрх зүйн практикт хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийсэн.
3	Сато Хироши	Япон	2021	Японы хууль эрх зүй ба нийгмийн сэтгүүл	Сонгодог криминологийн Японы эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө	Японы хууль эрх зүйн тогтолцоонд сонгодог криминологийн түүхэн нөлөөг судалсан.
4	Тан Чуан-Хонг	Малайз	2020	Малайзын Криминологийн сэтгүүл	Малайзын криминологи дахь сонгодог онолын хамаарал	Сонгодог онолууд Малайз Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегид хэрхэн тусгагдсан байдлыг судалсан.
5	Түмэнжаргал Наранбаатар	Монгол	2022	Хууль дээдлэх ёс	Сонгодог онол ба түүний Монгол дахь хэрэглээ	Криминологийн сонгодог онолуудыг Монголын нөхцөлд хэрхэн ашиглах талаар судалсан.
6	Чайяпорн Срисанг	Тайланд	2023	Тайландын Криминологийн сэтгүүл	Тайланд дахь гэмт хэргийн сонгодог хэтийн төлөв	Тайландын гэмт хэргийн чиг хандлагад сонгодог онолын хамаарлын талаар судалсан.
7	Чен Вэй	Тайвань	2024	Тайваний хуулийн тойм	Тайвань дахь криминологийн сэтгэлгээний хувьсал	Тайвань дахь сонгодог криминологийн онолын хөгжил, дасан зохицоход дүн шинжилгээ хийсэн.

8	Ахмад Захид	Малайз	2024	Гэмт хэрэг, шударга ёс, нийгмийн ардчиллын олон улсын сэтгүүл	Малайз Улсын криминологийн соёлын ялгааг арилгах	Малайз дахь гэмт хэрэг, шударга ёсонд үзүүлэх соёлын нөлөөг судалсан.
9	Ван Сяожун	БНХАУ	2024	Номхон Далайн Криминологийн сэтгүүл	Баруун болон Дорнодын криминологийг холбох: Харьцуулсан судалгаа	Барууны сонгодог онолуудыг гэмт хэргийн талаарх Дорно дахины үзэл баримтлалтай уялдуулах асуудлыг судалсан.
10	Ли Жун-Ён	Өмнөд Солонгос	2024	Гэмт хэрэг, шударга ёс, нийгмийн ардчиллын олон улсын сэтгүүл	Сонгодог онолын орчин үеийн Солонгосын эрүүгийн шүүхэд үзүүлэх нөлөө	Сонгодог онолууд Солонгосын орчин үеийн эрүүгийн эрх зүйн практикийг хэрхэн үргэлжлүүлэн бүрдүүлж байгааг үнэлсэн.

Лю Жианхун (2014), Азийн криминологийг гэмт хэрэг, шударга ёсыг Азийн нөхцөл байдалд тусгайлан судалдаг шинжлэх ухаан гэсэн тодорхойлолтыг дэвшүүлж, онцолсон. Тэрээр барууны парадигмуудын ноёрхлыг эсэргүүцэх замаар криминологийн мэдлэгийг колоничлоход хувь нэмэр оруулж, Азийн нийгмийн бодит байдлыг тусгасан шинэ онол, хэтийн төлөвийг санал болгож, улмаар дэлхийн криминологийн яриаг баяжуулж чадна гэж тэрээр үзсэн (Jianhong, 2014). Мөн тэрээр Азийн криминологитой эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэхийг уриалж, энэ чиглэлээр илүү олон судлаачид анхаарлаа хандуулах тусам энэ нь дэлхийн хэмжээнд криминологийн судалгааг ихээхэн ахиулна гэж үзсэн.

Ким Ён Сүгийн (2019), Солонгосын Криминологийн сэтгүүлд "Сонгодог криминологи ба түүний Өмнөд Солонгос дахь хэрэглээ" нэртэй нийтлэл нь Өмнөд Солонгосын хууль эрх зүйн практикт сонгодог криминологийн онолын нөлөөллийг судалсан. Тэрээр, Сонгодог криминологийн онол нь пропорциональ шийтгэлийг урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болгон сурталчилж, ирээдүйд гарах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд гэмт хэргийн ноцтой байдал нь хүнд байх ёстой гэж үздэг. Өмнөд Солонгосын өвөрмөц соёл, нийгмийн нөхцөлд сонгодог онолуудыг дасан зохицож байгааг онцолж, эдгээр онолууд нь суурь ойлголтыг өгдөг ч орон нутгийн зан заншил, нийгмийн хэм хэмжээ нь гэмт хэргийн зан үйл, хариу арга хэмжээг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг дурдсан (Yong-Soo, 2019).

Сато Хироши (2021) Сонгодог криминологийн Японы хууль эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө сэдэвт нийтлэлдээ сонгодог криминологийн онолууд Японы хууль эрх зүйн тогтолцоонд түүхэнд хэрхэн нөлөөлсөн талаар судалсан байдаг. Тэрээр, гэмт хэргийн ноцтой байдалд тулгуурлан шийтгэлийн хүндийг заасан хууль тогтоомжийг боловсруулахдаа хэрхэн баталсан талаар дүн шинжилгээ хийсэн ба гэмт хэргийн зан үйлийг хүмүүс таашаал авах эсвэл өвдөлтөөс ангижрахыг эрэлхийлдэг гедонист (*хүний амьдралын хамгийн дээд үнэ цэнэ нь таашаал ба амьдралдаа хамгийн их таашаалыг олохыг эрмэлздэг хүн бөгөөд түүний энэ хандлага нь хувь хүний болон нийгмийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг*) нүдээр харж болно гэсэн санааг судалдаг. Мөн өөрийн судалгааны үр дүнгээс сонгодог зарчмуудыг тусгаж, таслан зогсоох, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сүүлийн үеийн хууль эрх зүйн шинэчлэлийг тоймлон бичсэн нь Япон Улсын хууль эрх зүйн тогтолцоонд сонгодог криминологийн онолын түүхэн нөлөөг тодруулж, криминологи,

хуулийн талаарх ярианд үнэтэй хувь нэмэр оруулснаараа хүлээн зөвшөөрөгддөг (Hiroshi, 2021).

Тан Чуан-Хонг (2020) Малайз Улсын криминологийн сонгодог онолуудын хамаарал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегид хэрхэн тусгагдсаныг судалсан. Ингэхдээ гэмт хэргийг таслан зогсоохын тулд хатуу шийтгэл оногдуулах нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ болохыг дэмжиж гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хурдан бөгөөд тодорхой шийтгэл ногдуулах талаар дурдсан. Тэрээр онолын хувьд шударга хуулийн тогтолцоог онцолсон нь Малайз Улс дахь эрх зүйн шинэчлэлийг удирдан чиглүүлж, хууль тогтоомжийг ойлгомжтой, оновчтой олон нийтийн оролцоог чухал талаар тусгажээ (Chuan-Hong, 2020).

Түмэнжаргалын Наранбаатар (2022) криминологийн сонгодог онолын Монгол Улс дахь хэрэглээ бүтээлдээ Монголын уламжлалт хууль эрх зүйн тогтолцоо, орчин үеийн хууль эрх зүйн орчинтой хэрхэн нийцэж байгаа болон тэдгээрийн ялгаатай байдлын талаар тусгасан ба гэмт хэргийн хэв маяг, хууль эрх зүйн хариу арга хэмжээг ойлгоход сонгодог онолуудыг хэрхэн ашиглаж болохыг судалсан. Түүний судалгаа нь түүхэн эрх зүйн уламжлал, орчин үеийн эрх зүйн шинэтгэлийн аль алиныг нь харгалзан Монгол Улсын хууль эрх зүй, соёлын өвөрмөц нөхцөл байдалд сонгодог криминологийн онолуудыг хэрхэн хэрэглэж байгааг дурджээ.

ЧайяпORN Срисанг (2023) Тайланд Улсын гэмт хэргийн чиг хандлагыг сонгодог криминологийн онолын үүднээс судалсан ба ингэхдээ тус улсын хууль тогтоомж, бодлого нь сонгодог криминологийн зарчимтай хэрхэн нийцэж байгааг гаргасан. Өөрөөр хэлбэл Тайланд улсын хар тамхины наймаа, авлига, хүчирхийллийн гэмт хэргийн чиг хандлагыг тодорхойлж ял шийтгэлийг хангалттай хатуу эсвэл тодорхой заахгүй бол хүмүүс гэмт хэргийг сонгох талаар тусгажээ (Srisang, 2023).

Чен Вэй (2024) Тайваний криминологийн сэтгэлгээний хувьслыг судалж, сонгодог криминологийн онолын хөгжил, дасан зохицох асуудалд анхаарлаа хандуулсан ба цаг хугацааны явцад хэрхэн хөгжиж, сүүлийн үеийн хууль эрх зүйн шинэчлэл нь сонгодог криминологийн элементүүдийг багтаасан шударга ёсны тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготойг батлан харуулахыг зорьжээ (Wei, 2024).

Ахмад Захид (2024) Олон улсын гэмт хэрэг, шударга ёс, нийгмийн ардчиллын сэтгүүлд нийтлүүлсэн судалгааны ажилдаа Малайз Улс бол малай, хятад, энэтхэг, уугуул үндэстний соёлын нөлөө бүхий олон соёлт нийгэмтэй учир эдгээр соёлын ялгааг криминологийн сонгодог онолыг үүднээс судалсан. Тэрээр соёлын өөр өөр үзэл баримтлал нь гэмт хэргийн түвшин, хохирогчид хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх замаар эдгээрийг арилгах арга замыг ирэлхийлсэн ба "Соёлын цоорхой"-г арилгахад гэмт хэрэг, шударга ёсонд соёлын хүчин зүйлс хэрхэн нөлөөлдөг тухай ойлголтыг өгч, эрүүгийн эрх зүйн тогтолцоог сайжруулахын тулд соёлын эдгээр ялгааг ойлгож, шийдвэрлэхийн чухлыг онцолжээ (Zahid, 2024).

Ван Сяожүн (2024) Ази Номхон далайн Криминологийн сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлдээ барууны сонгодог криминологийн онолуудыг гэмт хэргийн талаарх Дорно дахины үзэл баримтлалтай нэгтгэх талаар судалсан ба гэмт хэргийн оновчтой сонголтын тал болон гэмт хэрэг гарч буй нийгэм, соёлын нөхцөл байдлыг хоёуланг нь харгалзан үзсэнээрээ онцлогтой. Улмаар Дорно дахины үзэл баримтлал, ялангуяа Хятад болон Азийн бусад орны үзэл баримтлалд нийгмийн эв найрамдал, хамт олон, ёс суртахууны боловсролыг чухалчилдаг соёл, гүн ухааны уламжлалыг агуулсан байдаг бол барууны баривчлах, шийтгэх онолууд нь нийгмийн нэгдэл, ёс суртахууны удирдамжийг онцолсон дорно дахины арга барилтай хэрхэн тэнцвэржүүлж болох талаар дүн шинжилгээ хийжээ (Xiaojun, 2024).

Ли Жун-Янг (2024) Олон улсын гэмт хэрэг, шударга ёс, нийгмийн ардчиллын сэтгүүлд нийдлүүлсэн судалгаандаа сонгодог криминологийн онолууд Өмнөд Солонгосын орчин үеийн эрүүгийн эрх зүйн практикт хэрхэн нөлөөлсөөр байгааг судалсан ба сүүлийн

үеийн хөгжилд дижитал гэмт хэрэгтэй тэмцэх системийг сайжруулах, хүүхэд, сурагчид зэрэг эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах талаар тусгажээ. Мөн Өмнөд Солонгосын хууль эрх зүйн тогтолцоонд уламжлалт Күнзийн үнэт зүйлс болон орчин үеийн хууль эрх зүйн шинэчлэл аль аль нь нөлөөлдөг талаар дурджээ (Joon-Young, 2024).

Дээрх эрдэмтдийн бүтээлийн харьцуулан авч үзвэл:

- Азийн улс орнуудын криминологийн судалгаанд соёлын өвөрмөц онцлогийг дурджээ. Тухайлбал, Ван Сяожүн (2024) барууны болон дорнын криминологийн онолуудыг хослуулан авч үзсэн бол Ахмад Захид (2024) Малайзын олон соёлт нөхцөлд соёлын ялгааг арилгахад анхаарах чиглэлээр судалжээ.
- Ихэнх судалгаанд сонгодог онолын зарчим болох шийтгэлийн пропорциональ байдал нь урьдчилан сэргийлэх талаар судалжээ. Тухайлбал, Тан Чуан-Хонг (2020) Малайзын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийг боловсруулсан бол Чайяпорн Срисанг (2023) Тайландын гэмт хэргийн чиг хандлагыг шинжлэн судалжээ.
- Түүхэн хууль эрх зүйн тогтолцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэх тал дээр судалгаа хийгдсэн байна. Тухайлбал, Сато Хироши (2021) Японы хууль эрх зүйн тогтолцоонд сонгодог криминологийн онолын түүхэн нөлөөг тайлбарласан бол Түмэнжаргалын Наранбаатар (2022) Монгол Улсын уламжлалт болон орчин үеийн хуулийн тогтолцооны уялдааг судалсан байна.

Барууны криминологийн сонгодог онолыг Азийн нөхцөлд тохируулан дасан зохицуулсан нь судалгааны нийтлэг арга зүй байх ба ял, шийтгэлийн хатуу байдал, хурд, тодорхой байдалд анхаарч, гэмт хэргийн зан үйлд нөлөөлөх арга замуудыг тодорхойлж, криминологийн онолыг орон нутгийн соёл, зан заншилтай холбосон нь онцлогтой гэж дүгнэж байна.

Харин Европын зарим улсын эрдэмтийн үзэл санааг харьцуулан авч үзвэл:

№	Улс	Эрдэмтдийн нэрс	Он	Эх сурвалж	Судалгааны ажлын нэр	Судалгааны тойм
1	Их Британийн Нэгдсэн Вант Улс	Дэвид Гарланд	1990	Онолын криминолог	Шийтгэл ба орчин үеийн нийгэм: Нийгмийн онолын судалгаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн хяналт, эрсдэлийн менежментийн үүрэгт анхаарлаа хандуулсан.
2	Герман Улс	Вольфганг Софский	1994	Гэмт хэрэг ба шударга ёс	Гэмт хэргийн дараалал: Нийгмийн дэг журам ба гэмт хэргийн шалгалт	Гэмт хэрэг ба нийгмийн дэг журам хоорондын хамаарлыг судалж, нийгмийн хариу үйлдлийг онцолсон.
3	Франц Улс	Мишель Фуко	1975	Сахилга ба шийтгэл	Шийтгэлийн хувьсал: Бүрэн эрхт эрх мэдлээс сахилга бат хүртэл	Шийтгэл дэх хүч чадлын динамик, бүрэн эрхт эрх мэдлээс сахилгын эрх мэдэл рүү шилжихэд дүн шинжилгээ хийсэн.

4	Итали Улс	Чезаре Беккариа	1764	Гэмт хэрэг ба ял шийтгэлийн тухай		Шийтгэл оновчтой байх нь урьдчилан сэргийлэх чухал ажил хэмээжээ.
5	Нидерланд Улс	Ян ван Дейк	2008	Европын Криминологийн сэтгүүл	Нийгмийн нөхцөл байдлын нөлөөллийн гэмт хэргийн түвшин ба хохирогчдод үзүүлэх нөлөө	Гэмт хэргийн түвшин болон хохирогчийн туршлагад хэрхэн нөлөөлж байгааг судалсан.
6	Швед Улс	Нилс Крист	1986	Гэмт хэрэг ба нийгмийн шударга ёс	Уламжлалт хууль эрх зүйн орчин нь хохирогчдын гадуурхал	Хохирогчдын хэрэгцээ, дуу хоолойг нэн тэргүүнд тавьсан шударга ёсыг сэргээх хандлагыг дэмжсэн.
7	Испани Улс	Франсиско Гонзалес де Коссио	2013	Олон улсын хууль, гэмт хэрэг, шударга ёс	Нийгэм дэх гэмт хэрэг, шударга ёсны соёл	Орчин үеийн нийгэм дэх гэмт хэрэг, шударга ёсны соёлын хэмжүүрийг судалсан
8	Белги Улс	Пол Понсаерс	2009	Европын Криминологийн сэтгүүл	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь	Европын нөхцөл байдалд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратегийг судалж, олон нийтийн оролцоо чухал болохыг онцолсон.
9	Норвеги Улс	Томас Угелвик	2014	Норвегийн эрүүгийн эрх зүйн тогтолцоо	Нордкийн шийтгэлийн онцгой байдлын талаарх харьцуулалт	Analyzes the effectiveness of rehabilitation versus punishment in criminal justice systems.
10	Финланд Улс	Хейкки О.А. Кививуори	2017	Скандинав судлалын сэтгүүл	Финлянд Улсын гэмт хэргийн чиг хандлага, урьдчилан сэргийлэх стратеги	Гэмт хэргийн нөхцөл байдлыг төдийгүй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг хэрхэн бүрдүүлдэг болохыг онцолсон.

Дэвид Гарланд (1990) "Онолын криминологи" бүтээл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нийгмийн хяналт, эрсдлийн менежментийн үүргийг чухалчилсан ба "Нийгмийн хяналт" гэдэг нь хувь хүний зан үйлийг зохицуулах, нийгмийн дэг журмыг сахиулах зорилгоор нийгэмд ашигладаг механизм, стратеги, институцийг хэлнэ хэмээжээ. Тэрээр гэр бүл, хамт олон гэх мэт албан бус нийгмийн хэм хэмжээ нь нийгмийн хяналтын уламжлалт хэлбэрүүд болох хууль сахиулах, эрүүгийн эрх зүйн тогтолцоо зэрэг албан ёсны механизмаар солигдсон гэж үзжээ. Энэхүү өөрчлөлт нь гэмт хэрэгтэй тэмцэх илүү институцилагдсан арга барилд хүргэсэн бөгөөд төр нь хууль эрх зүйн орчин, цагдаагаар дамжуулан хэв журмыг сахиулах гол үүрэг гүйцэтгэдэг. Харин Криминологийн эрсдэлийн менежмент нь олон нийтийн аюулгүй байдал, аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналыг үнэлэх, бууруулахад оршино гээд орчин үеийн нийгэм гэмт хэрэг үйлдэгдсэний дараа шийтгэл оногдуулахаас илүүтэй удирдаж болох эрсдэл гэж үзэх нь улам бүр нэмэгдсээр байгааг Гарланд онцолсон. Улмаар ял, шийтгэлийг урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл гэж үздэг сонгодог криминологийн онолыг шүүмжилсэн бөгөөд нийгмийн динамик, эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан илүү нарийн

ойлголт гэж үзжээ. Гарландын нийгмийн хяналт, эрсдэлийн менежментийн судалгаа нь криминологи дахь реактив арга хэмжээнээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн идэвхтэй стратеги руу шилжих парадигмын өөрчлөлтийг харуулсан ба орчин үеийн нөхцөлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга барилд нийгмийн өөрчлөлт хэрхэн нөлөөлж буйг цогцоор нь ойлгоход дэмжлэг үзүүлсэн байна (Garland, Punishment and Modern Society: A Study in Social Theory, 1990).

Вольфганг Софский (1994) "Гэмт хэрэг ба шударга ёс" нийтлэлдээ гэмт хэрэг ба нийгмийн дэг журам хоёрын нарийн уялдаа холбоог судалж, нийгмийн хариу үйлдэл нь гэмт хэргийн зан үйл болон нийгмийн өргөн хүрээг хамардаг байдлыг хэрхэн бүрдүүлдгийг онцолсон ба гэмт хэрэг нь зөвхөн хууль зөрчсөн үйлдэл биш, харин нийгмийн нөхцөл байдалд гүн гүнзгий шингэсэн үзэгдэл гэж үзсэн. Тэрээр нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлс нь гэмт хэргийн зан үйлийг юу болохыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг мөн нийгмийн хариу үйлдэл нь хувь хүнийг нийгмээс нөхөн сэргээх эсвэл цаашлаад холдуулж болно хэмээжээ. Хууль сахиулах, шүүх, хорих анги зэрэг байгууллагууд нь гэмт хэргийн эсрэг нийгмийн хариу үйлдлийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдгийг онцлоод гэмт хэрэг, шийтгэлийн нийгэмд үзүүлэх үр дагаврыг илүү өргөн хүрээнд авч үзэх бодлогыг дэмжиж байгаа бөгөөд зөвхөн шийтгэлийн арга хэмжээ нь гэмт хэргийн зан үйлийн үндсэн шалтгааныг үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй гэдгийг харуулдаг гэжээ. Гэмт хэргийн түвшин их байх нь нийгмийн эв нэгдлийг эвддэг бол нийгмийн хүчтэй холбоо нь гэмт хэргийн зан үйлийг таслан зогсооход хүргэдэг хэмээгээд олон нийтийн оролцоог дэмжих, нийгмийн тэгш бус байдлыг арилгах нь гэмт хэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлнэ гэж үзжээ (Sofsky, 1994).

Мишель Фукогийн (1975) "Сахилга ба шийтгэл: Шоронгийн төрөлт" гэсэн нийтлэл нь барууны нийгэм дэх шийтгэлийн хувьслыг судалсан, ялангуяа шилжилтийн үеийг судалсан чухал бүтээл юм. Энэхүү бүтээлд бүрэн эрхт эрх мэдэл, сахилгын эрх мэдэл гэсэн 2 нэр томъёо ашигласан ба дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: Бүрэн эрхт эрх мэдэл нь төвлөрсөн, үнэмлэхүй эрх мэдлээр тодорхойлогддог бөгөөд ихэвчлэн хаант засаглал эсвэл муж улсуудтай холбоотой, үүнийг шийтгэлийн хүрээнд авч үзвэл төрийн эрх мэдлийн хүчийг харуулах, айдас хүйдсээр дамжуулан нийгмийн дэг журмыг сахиулах зорилготой эрүүдэн шүүх, цаазаар авах ажиллагааны явцаар илэрдэг гэжээ. Харин сахилгын эрх мэдэл нь хяналтын илүү нарийн бөгөөд өргөн тархсан хэлбэр гээд шорон, сургууль, эмнэлэг зэрэг байгууллагуудаар дамжуулан зан үйлийг төлөвшүүлэх, "зөөлөн бие"-ийг бий болгохын тулд тандалт, хэвийн байдал, шалгалт гэх мэт арга техникийг ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг гэжээ. Тэрээр бүрэн эрхт эрх мэдлээс сахилга бат руу шилжих шилжилт нь нийгэм хувь хүмүүст хяналт тавих арга хэлбэрт илүү өргөн хүрээний өөрчлөлтийг харуулж байна гэж Фуко үзээд орчин үеийн шорон, ялангуяа Жереми Бентамын зохион бүтээсэн шоронгийн Паноптикон (байнгын ажиглалт хийх боломжийг олгож, хувь хүмүүс зан үйлийн хэм хэмжээг шууд ажиглаагүй байсан ч ажиглаж байгаа гэж бодох орчныг бүрдүүлсэн) загварыг дэмжжээ (Foucault, 1975).

Чезаре Беккариа (1764) "Гэмт хэрэг ба шийтгэлийн тухай" бүтээл нь криминологийн салбарын үндэс суурь болсон зохиол юм. Энэ нь ял, шийтгэлийн оновчтой байдлыг дэмжиж, хууль тогтоомжийн таслан зогсоох үр нөлөөг онцлон тэмдэглэдэг. Беккариагийн онолын үндсэн зарчмуудыг авч үзвэл:

- Ял, шийтгэлийн зорилго нь урьдчилан сэргийлэх явдал,
- Ял, шийтгэл нь гэмт хэрэгтэй пропорциональ байх ёстой бөгөөд гэмт этгээдийн санаа зорилгоос илүү учруулсан хохирлыг харгалзан үзэх ёстой,
- Ял, шийтгэл нь олон нийтэд нээлттэй, шуурхай байх шаардлагатай. Энэ нь олон нийтийн оюун санаанд гэмт хэргийг таслан зогсоох нөлөөг нэмэгдүүлнэ

- Эрүүдэн шүүхийг эрс эсэргүүцсэн ба нэн шаардлагатайгаас бусад тохиолдолд цаазаар авах ялыг үгүйсгэдэг
- Ял, шийтгэлийг хууль тогтоомжоор тогтоож, бүх хүнд адил тэгш хэрэглэх ёстой. Шүүгчид хууль тогтоомжийг өөрчлөх, шийтгэлийг дур мэдэн шийдвэрлэх эрх мэдэлтэй байх ёсгүй
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд боловсрол чухал гэдгийг тэрээр онцлоод хууль, түүний үр дагаврыг ойлгосноор хувь хүн гэмт хэрэг үйлдэх нь багасна гэжээ.

Ян Ван Дейк (2008) "Нийгмийн нөхцөл байдлын нөлөөллийн гэмт хэргийн түвшин ба хохирогчдод үзүүлэх нөлөө" нийтлэлдээ нийгмийн янз бүрийн нөхцөл байдал гэмт хэргийн түвшин болон хохирогчдод хэрхэн нөлөөлж байгааг судалсан. Тэрээр нийгмийн сүлжээтэй бүс нутагт оршин суугчдын дунд нийгмийн хяналт, дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн гаралт буурч магадгүй мөн гэмт хэргийн хохирогч болох хүнийг тодорхойлоход нийгэм эдийн засгийн байдал, үндэс угсаа, олон нийтийн онцлог зэрэг хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг гэсэн санааг дэвшүүлсэн ба гэмт хэргийн түвшин, хохирогчийн туршлагад нийгмийн нөхцөл байдлын нөлөө чухал хэмээжээ (Dijk, 2008).

Нилс Кристи (1986) "Гэмт хэрэг ба нийгмийн шударга ёс" сэтгүүлд хэвлэгдсэн "Нөхөн сэргээх шударга ёсны тухай" судалгааны ажил нь хохирогчдын хэрэгцээ, дуу хоолойг нэн тэргүүний асуудал гэж үзээд шударга ёсыг сэргээх хандлагыг дэмждэг ба ердийн шийтгэлийн тогтолцоог шүүмжилжээ. Тэрээр хохирогчид хуулийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос илүүтэй хэрэг дээрээ идэвхтэй оролцох ёстой гэж үзэн эрүүгийн эрх зүй дэх төрийн үүргийг шүүмжилсэн бөгөөд энэ нь ихэвчлэн зуучлагч гэхээсээ илүү зөрчилдөөний хулгайч үүрэг гүйцэтгэдэг гэж үзжээ (Christie, 1986).

Гонзалес де Коссио (2013) "Гэмт хэрэг шударга ёсны соёлын хэмжүүр" сэдэв судалгааны бүтээлдээ гэмт хэрэг нь зөвхөн хууль эрх зүйн ойлголт биш, харин соёлын нөхцөл байдалд гүн гүнзгий шингэсэн сөрөг асуудал гэдгийг онцлоод нийгмийн хэм хэмжээ, үнэлэмж, итгэл үнэмшил нь гэмт хэргийг хэрхэн тодорхойлж хүлээн зөвшөөрөх, түүнчлэн шударга ёсыг хэрхэн хэрэгжүүлэхэд нөлөөлдөг гэж үзжээ. Мөн даяаршил нь орон нутгийн соёлд хэрхэн нөлөөлж, гэмт хэрэгт үзүүлэх хариу арга хэмжээний талаар авч үзсэн бөгөөд соёлууд харилцан үйлчлэхийн хэрээр шударга ёсны талаарх уламжлалт үзэл бодол өөрчлөгдөж, гэмт хэргийн шинэ хэлбэр бүрэлдэж түүнд үзүүлэх хариу үйлдэл шинээр бий болдог талаар баталжээ (Cossio, 2013).

Пол Понсаерсын (2009) "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги" нийтлэлдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо чухал болохыг онцлоод хууль сахиулах байгууллагууд болон орон нутгийн хамтын ажиллагаа хэр үр дүнтэй болохыг судалж аюулгүй байдал, аюулгүй байдалтай холбоотой шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах стратегийг сурталчилсан. Тэрээр цагдаагийн байгууллагын уламжлалт дээрээс доош чиглэсэн арга барил нь олон нийтийн гишүүдийн өгч чадах үнэ цэнтэй ойлголт түүний хувь нэмрийг үл тоомсорлодог хэмээн үзжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь цагдаа, иргэдийн хамтын хүчин чармайлтаар аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн өөрөөр хэлбэл цагдаагийн үр дүнтэй стратегийн тулгийн чулуу болох олон нийтийн оролцоог сурталчлах нэмэгдүүлэх замаар үр дүнд хүрнэ гэжээ (Ponsaers, 2009).

Томас Угелвик (2014) шийтгэлийн онцгой байдлын талаарх судалгааны ажлаараа Скандинавын орнуудын эрүүгийн практикийн өвөрмөц шинж чанарууд, ялангуяа шийтгэлийн арга хэмжээнээс илүү нөхөн сэргээлтийг онцолж, гэмт хэрэгтнүүдийг зүгээр нэг шийтгэхээс илүүтэй нийгэмд эргүүлэн оруулах зорилготой нөхөн сэргээлтийг нэн тэргүүнд тавьжээ. Өөрөөр хэлбэл Норвегийн нөхөн сэргээх үйл ажиллагааны загвар нь гэмт хэрэгтний амьдралын аль ч үе шатанд хүмүүнлэгээр хандах, хэвийн болгох, өөрчлөгдөх боломжийг чухалчлаад шоронгуудын дизайн, үйл ажиллагаанд тусгалаа олсон бөгөөд

эдгээрийг уламжлалт шийтгэх байгууламжаас илүү халамжийн байгууллагуудтай илүү төстэй гэж тодорхойлсон (Ugelvik, 2014).

Хейкки О.А. Кививуори (2017) Скандинав судлалын сэтгүүлд нийтлүүлсэн судалгаандаа Финлянд улсын гэмт хэргийн чиг хандлага, урьдчилан сэргийлэх стратегид нийгмийн бодлого хэрхэн нөлөөлж байгааг судалсан байна. Энэхүү судалгаа нь нийгмийн бодлого нь гэмт хэргийн нөхцөл байдлыг төдийгүй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг хэрхэн бүрдүүлдэг талаар онцлоод төрийн эрх баригчид, бизнес эрхлэгчид, төрийн бус байгууллагууд зэрэг янз бүрийн оролцогч талуудын хамтын ажиллагаанаас үүдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц стратегиудын асуудлыг хөндөн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр нь олон нийтийн оролцоо, орон нутгийн оролцогчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх замаар үр дүнд хүрнэ хэмээжээ (Kivivuori, 2017).

Эдгээр судалгааны ажлууд нь гэмт хэрэг, шударга ёсны асуудалд хандах хандлага улам бүр өөрчлөгдөж байгааг харуулж байна. Зөвхөн шийтгэхээс илүүтэйгээр урьдчилан сэргийлэх, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх, хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтнүүдийг нөхөн сэргээхэд анхаарлаа хандуулж байна. Судлаачдын үзэл баримтлалыг харьцуулан авч үзвэл:

- Дэвид Гарланд, Вольфганг Софский, Мишель Фуко, Ян Ван Дейк нар нийгмийн хяналт, эрх мэдлийн янз бүрийн хэлбэрүүд нь гэмт хэрэгтэй хэрхэн холбогддогийг судалж, нийгмийн хүчин зүйлс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй гэдгийг онцолсон.

- Ял шийтгэл, шударга ёсны талаар Чезаре Беккариа ял шийтгэлийн зорилго нь урьдчилан сэргийлэхэд чиглэгдэх ёстой, ял шийтгэл нь гэмт хэрэгтэйгээ пропорциональ байх ёстой гэж үзсэн бол Нилс Кристи хохирогчдын хэрэгцээг нэн тэргүүнд тавьж, шударга ёсыг сэргээх хандлагыг дэмжсэн. Харин Томас Угелвик Скандинавын орнуудад нөхөн сэргээлтийг шийтгэлээс илүү чухалчилдаг гэжээ. Эдгээрээс дүгнэвэл ял шийтгэлийн зорилго, шударга ёсны үнэ цэнийн талаарх эдгээр судлаачдын үзэл бодол өөр өөр боловч бүгд шударга ёсны тогтолцоог сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байна.

- Гонзалес де Коссио, Пол Понсаерс, Хейкки О.А. Кививуори гэмт хэргийн шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замын талаарх эдгээр судлаачдын үзэл бодол нь нийгэм, соёл, олон нийтийн оролцоо гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэгтэй гэдгийг харуулж байна.

Орчин үеийн криминологийн судалгаа нь гэмт хэргийн шалтгааныг нийгэм, соёл, эдийн засгийн хүчин зүйлстэй холбон тайлбарлахыг эрмэлздэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, нийгмийн бодлого чухал үүрэгтэй. Эдгээр судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид, хууль сахиулах байгууллагууд, нийгмийн ажилтнууд гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй стратеги боловсруулахад ашиглах боломжтой юм.

Криминологийн сонгодог онол нь хууль эрх зүйн шударга ёс, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох суурь үндэслэл болж байна. Энэхүү онол нь хүний сонголт, ухамсрыг голлон авч үзэхээс гадна, ял шийтгэлийн үр дүнтэй байдал, шударга ёсны зарчмыг бататгасан. Орчин үеийн нийгэмд энэ онолыг соёл, нийгмийн орчинд уялдуулан ашиглах нь нийгмийн эв нэгдлийг хамгаалах, гэмт хэрэг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Дүгнэлт

Криминологийн сонгодог онол нь гэмт хэргийн шалтгааныг хувь хүний оновчтой сонголт, ашиг хожлын тооцоонд тулгуурлан тайлбарладаг бөгөөд энэ нь орчин үеийн эрүүгийн эрх зүйн тогтолцооны үндэс суурийг бүрдүүлдэг. Чезаре Беккариа, Жереми

Бентам зэрэг сэргэн мандалтын үеийн сэтгэгчдийн үзэл санаа нь шударга, хуульд суурилсан ял шийтгэлийн тогтолцоог хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд шийтгэл нь гарцаагүй, шуурхай, оновчтой байх шаардлагатай гэсэн сонгодог криминологийн зарчмууд өнөөгийн олон улсын эрх зүйн системд хэвээр үйлчилж байгаа ч, нийгэм, соёлын хүчин зүйлсийг харгалзан үзэх нь чухал болж байна. Монголын нөхцөлд энэ онолыг хэрэгжүүлэхдээ уламжлалт эрх зүйн тогтолцоотой уялдуулах, эрүүгийн бодлогод соёлын болон нийгмийн хүчин зүйлсийг тусган хөгжүүлэх шаардлагатай.

Орчин үеийн криминологи зөвхөн шийтгэл оногдуулах төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх асуудлыг чухалчилж байна. Иймээс криминологийн сонгодог онолыг орчин үеийн нөхцөл байдалд нийцүүлэн хөгжүүлэх, улс орнуудын эрх зүйн тогтолцоо, соёлын онцлогт тохируулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Ашигласан материал

1. Christie, N. (1986). The traditional legal framework discriminates against victims. *Crime and Social Justice*, 89-96.
2. Chuan-Hong, T. (2020). The Relevance of Classical Theories in Malaysian Criminology. *Malaysian Journal of Criminology*, 85-92.
3. Cossío, F. G. (2013). Journal of Law, Crime and Justice . *Crime and justice culture in society* , 145-155.
4. Dijk, J. v. (2008). The Impact of Social Contexts on Crime Rates and Victimization . *European Journal of Criminology* , 92-97.
5. Foucault, M. (1975). The Evolution of Punishment: From Sovereign to Disciplinary Power. *Discipline and Punish* , 143-157.
6. Garland, D. (1990). "Punishment and Modern Society: A Study in Social Theory". *Theoretical Criminology* , 178-183.
7. Garland, D. (1990). Punishment and Modern Society: A Study in Social Theory. *Theoretical Criminology*, 178-186.
8. Garland, D. (1990). Punishment and Modern Society: A Study in Social Theory. *Punishment and Modern Society: A Study in Social Theory*, 187-195.
9. Hiroshi, S. (2021). The Impact of Classical Criminology on Japanese Legal Frameworks. *Japanese Journal of Law and Society*, 50-55.
10. Jianhong, L. (2014). Asian paradigm theory. *International Journal for Crime, Justice and Social Democracy*, 231-238.
11. Joon-Young, L. (2024). Classical Theory's Influence on Modern Korean Criminal Justice. *International Journal for Crime, Justice and Social Democracy*, 121-130.
12. Kivivuori, H. O. (2017). Crime trends and prevention strategies in Finland. *Journal of Scandinavian Studies*, 121-132.
13. Ponsaers, P. (2009). Crime prevention. *European Journal of Criminology*, 202-209.
14. Sofsky, W. (1994). The Order of Crime: An Examination of Social Order and Crime. *Crime and Justice*, 97-117.
15. Srisang, C. (2023). Classical Perspectives on Crime in Thailand. *Thai Journal of Criminology*, 275-286.

16. Ugelvik, T. (2014). Comparison of Nordic punishment exceptions. *Nordic Studies on Crime and Justice*, 189-197.
17. Wei, C. (2024). The Evolution of Criminological Thought in Taiwan. *Taiwan Law Review*, 99-105.
18. Xiaojun, W. (2024). Bridging Western and Eastern Criminology: A Comparative Study. *Asia-Pacific Journal of Criminology*, 178-183.
19. Yong-Soo, K. (2019). Classical Criminology and Its Application in South Korea. *Korean Journal of Criminology Classical Criminology and Its Application*, 108-203.
20. Zahid, A. (2024). Bridging Cultural Gaps in Malaysian Criminology. *International Journal for Crime, Justice and Social Democracy*, 157-163.
21. Б.Мөнх-Эрдэнэ. (2021). Гэмт хэрэг судлалын онол. Улаанбаатар хот: "Өнгөт талст" ХХК.
22. Д.Зүмбэрэлхам. (2022). Криминологийн онол. Улаанбаатар хот.
23. Э.Дашгаадан. (2022). Криминологийн онолууд. In О. Долу. Улаанбаатар: "Бэмби сан" .